**Самбар 18** **Монгол орны мод сөөг** Эмхэтгэсэн: Манфред Веспер, Любек

## Holunder | Гандигар | Sambucus manshurica

| Герман нэршил | Монгол нэршил | Латин нэршил |
| --- | --- | --- |
| Holunder | Гандигар | Sambucus manshurica |
| | Монголд 2 зүйл | |







Гандигарын жимс

**Тодорхойлолт:**

Гандигар нь ой тайгын бүсэд зонхилон тархсан 3 метр хүртэл ургадаг сөөг юм. Зураг дээр Хэнтий аймгийн Биндэрийн овоон дээрх гандигар байна. Навч нь 3-9 навчинцар бүхий өрөөсгөл өдлөг, хөрөөлөг ирмэгтэй. Баг цэцэгтэй, дэлбэ нь шаравтар бөгөөд тод улаан өнгийн бөөрөнхий жимс гарна. Мөчир нь дотооддоо цайвардуу өнгөтэй.

**Мэдээлэл:** Харьцангуй ховорт тооцогдох энэхүү сөөгийг цэцэрлэг, хүрээлэнгүүдэд илүүтэй тарих хэрэгтэй.

**Грайфсвалдын Их Сургуулийн гербари** http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora_search=Taxon&action=species&gen=Sambucus

Дэлгэрэнгүй мэдээлэл, тархалтын зураг болон бусад зургуудтай дээрх холбоосоор орж танилцана уу.